



## “Ажлын байр, эдийн засгийн өсөлтөд чиглэгдсэн татварын хөнгөлөлт”

Монгол Улсын Засгийн Газар нь ажиллах хүчин, бизнесүүдэд ногдох татварын ачааллыг хөнгөлөх, хувийн салбарын өсөлтийг хурдасгах, дэлхийн хэмжээнд тус улсын өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд чиглэгдсэн татварын бодлогын шинэтгэлийг хийхээр ажиллаж байна.

”Эдийн засгийн чадавхийг бэхжүүлж, өрсөлдөх чадварыг хангахад чиглэгдсэн” татварын багц хуулийн шинэтгэл нь дараах зорилтуудад чиглэгдэж байна. Үүнд:

1. Шинэ ажлын байр бий болгож, бизнес эрхлэгчдэд ногдох татварын ачааллыг бууруулах замаар өрсөлдөх чадварыг дээшлүүлэх
2. Цалин хөлсний татварын хэмжээг багасган, ажиллах хүчний зардлыг бууруулснаар ажиллах хүчинд ногдох татварын дарамтыг хөнгөлөх
3. Татварын албаны үйл ажиллагааг хөнгөн шуурхай болгох, үйлчилгээг татвар төлөгчдөд үзүүлэх чиглэлд түлхүү анхаарах
4. Татварын дарамтыг багасгаснаар далд эдийн засгийг бууруулж татварын баазыг нэмэгдүүлэх
5. Татварын ялгавартай байдлыг арилгаж, дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих
6. Татварын тогтолцоог зөв гольдролд оруулснаар санхүүгийн найдвартай орчныг бий болгох.

Дээрх зорилтуудыг хангахаар санал болгож буй татварын шинэтгэлийн багц нь доорхи онцлогуудыг агуулж байна. Үүнд:

- Татварын хөнгөлөлт нь шинээр ажлын байр бий болгох замыг компаниудын өмнө нээж өгснөөр улам олон иргэдийн хувьд эдийн засгийн ирээдүйд оролцох боломжийг өргөжүүлэх
- Татварын шударга хувь хэмжээг тогтоосноор иргэдийн эдийн засгийн өсөлтөд идэвхтэй оролцох боломжийг хялбарчлах
- Татварын шударга хувь хэмжээг тогтоосноор ажиллах хүчинд ногдох татварын дарамтыг бууруулж, тэдний бодит орлогыг нэмэгдүүлэх
- Өрсөлдөх чадварыг дэмжсэн татварын хөнгөлөлт нь ажил олгогч, ажиллах хүчинд ногдох татварын ачааллыг багасган, улмаар компаниудын шинэ бүтээл, өсөлтөд оруулах шаардлагатай хөрөнгө оруулалтын чухал эх үүсвэрийг чөлөөлж өгөх
- Эдийн засгийн чадавхийг бүхэлд нь бэхжүүлснээр иргэдийн орлого нэмэгдэн далд эдийн засаг буурч татварын бааз суурь нэмэгдэх бөгөөд шинээр ажлын байр бий болгох боломж бүрдэх.